

ДААТГАЛЫН МЭДЭЭ

2010 оны 02 дугаар сар

1. САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЭЛ:


Даатгалын компаниудын даатгалын үйл ажиллагааны үндсэн үзүүлэлтүүдийг 2010 оны 2 дугаар сарын байдлаар харуулбал:

Ердийн даатгалын компаниудын хувьд : /төгрөгөөр/

	Үзүүлэлт	2010-I	2010-II
1	Даатгалын нийт хураамж	910 215 852,0	1 399 842 720,5
2	Олгосон нийт нөхөн төлбөр	404 565 632,0	345 313 222,1
3	Давхар даатгалд төлсөн хураамж	53 027 158,0	150 552 151,0
4	Байгуулсан даатгалын гэрээний тоо /ширхэг/	5 787,0	3 872,0
5	Даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр үнэлгээний дүн	200 000 000 000,0	49 097 880 000,0
6	Хамгийн их дүнтэй нөхөн төлбөрийн дүн	37 513 684,0	37 145 000,0

Даатгалын компаниудаас 2 дугаар сард хамгийн их дүнтэй нөхөн төлбөрийг “Монгол даатгал” ХХК нь “Виста экспертиз” ХХК-ийн авто тээврийн хэрэгслэлийн даатгалын гэрээний нөхөн төлбөрт 37,1 сая төгрөг олгосон байна.

Даатгалын компаниудын даатгалын хураамжийн орлого болон нөхөн төлбөрийн харьцаа, сая төгрөгөөр



Даатгалын компаниудын 2 дугаар сард төвлөрүүлсэн даатгалын хураамжийн орлого 1 дүгээр сарынхаас 53,7 хувиар нэмэгдсэн бол даатгалын нөхөн төлбөр 2 дугаар сард 1 дүгээр сарынхаас 14,6 хувиар буурсан байна.

Урт хугацааны даатгалын компанийн хувьд :

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2010-I	2010-II
1	Даатгалын нийт хураамж	2 570 746,23	40 929 451,00
2	Олгосон нийт нөхөн төлбөр	410 000,00	1 935 917,28
3	Давхар даатгалд төлсөн хураамж	-	-
4	Байгуулсан даатгалын гэрээний тоо	11 гэрээ	9 гэрээ
	Үүнээс: -Хувь хүний хугацаат даатгалд	6 гэрээ	4 гэрээ
	-Байгууллагын хугацаат даатгалд	1 гэрээ /177/	5 гэрээ /686 хүн/
	-Өндөр хамгаалалттай ЭМД-д	4 гэрээ /12 хүн/	0
5	Даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр үнэлгээний дүн	10 000 000,00	20 000 000,00
6	Хамгийн их дүнтэй нөхөн төлбөрийн дүн	360 000,00	400 000,00

“Нэйшнл лайф даатгал” ХХК нь 2 дугаар сард хийгдсэн даатгалын гэрээнүүдээс “Хувь хүний хугацаат амьдралын даатгал”-ын гэрээгээр 4 хүн, “Байгууллагын хугацаат амьдралын даатгал”-ын 5 гэрээгээр 686 хүнийг даатгалд хамруулж 40,9 сая төгрөгийн хураамжийн орлогыг төвлөрүүлсэн нь 1 дүгээр сард төвлөрүүлсэн даатгалын хураамжийн орлогоос 15,9 дахин өссөн байна.

Гэнэтийн осол, эмнэлгийн мөнгө нэмэлт нөхцөлөөр 1,9 сая төгрөгийн нөхөн олговор олгосон байна.